НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 17 өдөр Дугаар А/95 Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Боловсролын
хэлтсийн балансаас хөрөнгө
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,867,084.40 (гурван сая найман зуун жаран долоон мянга наян дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянгол дүүргийн Оюуныундраа цогцолбор сургууль, Баянгол дүүргийн 40 дүгээр сургуулийн балансад тус тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс (Л.Жаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянгол дүүргийн Оюуныундраа цогцолбор сургууль (С.Нэргүйдаваа)-д, Баянгол дүүргийн 40 дүгээр сургууль (Б.Балган)-д тус тус үүрэг болгосугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс (Л.Жаргал)-т, Баянгол дүүргийн Оюуныундраа цогцолбор сургууль (С.Нэргүйдаваа)-д, Баянгол дүүргийн 40 дүгээр сургууль (Б.Балган)-д тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА М.БАЯРАА

1119282495 ☎ 2678589

115050000329

Тушаал-2021